ӨМГӨӨЛЛИЙН НИЙСЛЭЛ АДВОКЭЙТС ХХК

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Байгууллагын нууцын тухай хууль

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан
1995 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэг

Монгол Улсын иргэн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.



Байгууллагын нууц

Байгууллагын нууц гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд болон тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон ***мэдээ, баримт бичиг, биет зүйл***ийг хэлнэ.

Байгууллага гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болох бөгөөд энэхүү нууцыг **байгууллага өөрөө тогтооно.**

Байгууллагын нууцын ангилал

Байгууллагын нууц

Үйлдвэрлэлийн нууц
үйлдвэрлэлийн арга технологи, шинэ техник,бүтээх арга г.м

Санхүү, худалдааны нууц
нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүд, цалин хөлс тогтоох арга г.м

Мэдээллийн нууц

- ✓ Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан нь хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу байгууллагын нууцтай танилцахад саад учруулж болохгүй.
- ✓ Ийнхүү танилцсан байгууллага, тэдгээрийн ажилтан нь уул нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

Байгууллагын нууцыг хамгаалах

Байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байх бөгөөд байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө.

Байгууллагын нууцыг хариуцаж байгаа, эсхүл түүнтэй албан үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны дагуу танилцсан, олж мэдсэн этгээд уул **нууцыг чанд хадгалах үүрэгтэй.**

Байгууллагын нууцаа хамгаалах зохицуулалт

- ✓ Нууцад тооцогдох мэдээллүүдийг зэрэглэх
- ✓ Мэдээлэл авч ашиглах ажилтнуудыг тогтоох
- ✓ Хөдөлмөрийн гэрээнд нууцын тухай заалт оруулах
- ✓ Нууцыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэсэн тоног төхөөрөмж, компьютер хэрэгслэлийг кодлох зэрэг олон аргуудыг хэрэглэдэг.

Байгууллага нь эрхэлж буй үйл ажиллагааныхаа дагуу олж мэдсэн хувь хүний нууцыг байгууллагын нууцын нэг адил хамгаална.

Нууцалж болохгүй мэдээлэл

Байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл

Байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл

Гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээлэл.

Асуудлаа шийдвэрлүүлэх арга зам

- Хөдөлмөрийн гэрээ болон контракт гэрээ, нууцын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу байгууллагын нууцыг бусдад задруулсан бол Иргэний хэргийн анхан шатны шүүхэд /Хэрвээ гэрээнд арбитрын шүүхээр маргааныг хянан шийдвэрлэхээр зохицуулсан тохиолдолд арбитрын шүүхэд/ хандана.
- Байгууллагын нууцтай холбоотой цахим мэдээлэлд хууль бусаар халдсан, олж авсан мэдээллийг бусдад тараасан бол Цагдаагийн байгууллагад хандана.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- Байгууллагын нууцыг хариуцдаг, эсхүл түүнтэй танилцсан этгээд нууцыг задруулсан бол хөдөлмөрийн гэрээ болон тухайн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- Тухайн нууц задруулсан үйлдэл нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй тохиолдолд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан холбогдох хариуцлагыг хүлээлгэж болно.

Зөвлөмж

Байгууллагын нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйл нь хүний эрх, нэр төр, алдар хүнд болон тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлхүйц мэдээ, мэдээллийг агуулсан байдаг тул та бүхэн байгууллагын аливаа нууцыг бусдад задруулах, бусдын аливаа халдлагаас урьдчилан сэргийлж, анхаарал болгоомжтой байгаарай.

ӨМГӨӨЛЛИЙН
НИЙСЛЭЛ
АДВОКЭЙТС
ХХК

Анхаарал хандуулсанд баярлалаа